

**ЭМИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ШАЛТГААН, НӨХЦӨЛИЙГ
ХЯНАН ШАЛГАХ ҮҮРЭГ БҮХИЙ ТҮР ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-8

1.Хянан шалгах түр хорооны даргыг сонгох 3-8

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг
хянан шалгах үүрэг бүхий түр хорооны
10 дугаар сарын 04-ний өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 09 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Нэг.Хянан шалгах түр хорооны даргыг сонгох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, референт Ж.Лхагвасүрэн, К.Пүрэвсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан Хянан шалгах түр хорооны даргад Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнг дэвшүүлэв.

Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Б.Бейсен нарын тавьсан асуултад нэр дэвшигч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Б.Бейсен: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнг Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий түр хорооны даргаар сонгох саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 0
Бүгд: 7
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх сонгох саналыг дэмжсэн тул Түр хорооны тогтоол батлагдсанд тооцов.

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн 11 цаг 32 минутаас хуралдааныг даргалж, үг хэлэв.

Уг асуудлыг 11 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Хянан шалгах түр хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 24 минут үргэлжилж, 7 гишүүнээс 7 гишүүн хүрэлцэн ирж, 100 хувийн ирцтэйгээр 11 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 04-ний өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжсин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 09 минут.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Б.Бейсен: Эрхэм гишүүдэд өнөөдрийн амар амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны гишүүдийн ирц бүрдсэн тул Түр хорооны 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Хурлын ирцийг танилцуулъя. Дамбын Батлут ирсэн байна, Бадарчийн Жаргалмаа ирсэн байна, Буланы Бейсен ирсэн, Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн ирсэн байна, Сандаг-Очир гишүүн чөлөөтэй юм байна, ирэх юм уу, ирж байгаа юм байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн ирсэн, Цэвэгдоржийн Туваан ирсэн байна. Ирц 71,4 хувьтай байна. 85,7 хувьтай юм байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Хэлэлцэх асуудал нэг Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны дарга сонгох. Хэлэлцэх асуудлын талаар өөр саналтай гишүүн байна уу? Саналтай гишүүн байхгүй тул одоо хэлэлцэх асуудалд орёе.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 Түр хорооны даргыг түр хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно гэж заасан байна. Ингээд түр хорооны даргад нэр дэвшүүлэх саналтай гишүүд байвал нэрсээ өгнө үү. Туваан гишүүн, өөр гишүүн байна уу? Чинбүрэн гишүүн бас

санал хэлэх юм байна. Санал хураалтыг таслах уу тэгвэл. Туваан гишүүн, Чинбүрэн гишүүн байна. Оюунчимэг гишүүн, Чинбүрэн гишүүн 2-ыг оруулчихаарай. Туваан гишүүн.

Ц.Туваан: Бид бүхэн бас чуулганы хуралдаан эхэлсэн. Тэгээд энэ чуулганы завсарлагаагаар гишүүд орон нутагт, гадаадад ингээд ажилтай байсан учраас энэ ажил маань бас жоохон цаг алдчихлаа. Тэгэхээр одоо бол хэдүүлээ маш шуурхай тавиад, хугацаа ч нэлээн богино байгаа байх 2 сарын л хугацаа байгаа байх. Тэгэхээр энэ хугацаандаа нэлээн шахуу ажиллая. Дээрээс нь энэ Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль маань ингээд нэг өргөн баригддаг, буцаад татагддаг ингээд энэ асуудал байгаа. Тэгэхээр энд болон энэ ЭМЯ Засгийн газарт бас яг энэ эмийн бодлого дээр нэлээн түлхэц өгөх зөвлөмжийг, шийдвэрийг энэ Түр хорооноос гаргах учиртай гэж ингэж ойлгож байгаа. Тэгээд бүгдээрэнд нь амжилт хүсье.

Тэгээд би энэ юу Чинбүрэн гишүүнийг бас дарга болоод энэ ажлаа, санаачилсан ажлаа бас ахлаад яваасай гээд бодож байна. Тэгээд нэрийг нь дэвшүүлж байна.

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Туваан гишүүний хэлж байгаа бас үнэн. Бид одоо Их Хурлын тогтоол гараад 6 сарын 30-наас хойш бүтэн 3 сар өнгөрчихсөн. Тэгээд өмнөх Эмийн түр хороо байгуулагдаад бас одоо олигтой шийдвэр гаргаж чадалгүй ингээд дараагийн түр хороо байгуулагдсан. Тийм учраас эрүүл мэндийн салбарын гол зэвсэг болдог энэ эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанар, тэдгээрийн үнэ, ялангуяа төрөөс хөнгөлөлт үзүүлэн худалдаж авч байгаа зайлиггүй шаардлагатай эмийн жагсаалт хэрхэн бүрддэг юм, түүний үнэ нь яаж бүрддэг юм, дээрээс нь ямар нэг тийм нөлөөллийн ажлууд энэ жагсаалтад ороход байдаг уу үгүй юү? Ер нь Монголын эрүүл мэндийн салбарт энэ

эмийн бизнест монопол болон олигопол тогтолцоо байгаа юу үгүй юү гээд маш олон зүйлийг бид энд зайлиггүй ярилцах ёстой. Тэгээд 6 сар ажиллах ёстой түр хороо маань үндсэндээ 50 хувь нь хугацаанд 3 сар нь ингээд бид ажиллаж чадахгүй байсаар байгаад өнгөрсөн.

Тийм учраас олон нийт ер нь юу гэж харж байгаа вэ гэхээр ер нь энэ эмийн зохицуулалтаа төр өөрөө хийж чадах юм уу, Их Хурал энэ Эмийн хяналтын түр хороо ажлаа хийж чадах уу үгүй юү гэдэгт бас эргэлзэх тийм хүртэл байдалд орохоор ноцтой байдал үүсээд байгааг би бас эрхэм гишүүдэд зориуд уламжилмаар байна. Тийм учраас бид бас энэ дээр нэлээн анхааралтай хянан шалгах экспертүүдээ энэ тэр тавьж, хурдан ажиллах маш шуурхай хурдан ажиллах. Бас нэг чухал зүйл бол Эм, эмнэлгийн хэрэглээний тухай хуулийн төсөл 21 онд Засгийн газар өргөн бариад, тэгээд миний бие ажлын хэсгийг ахалж ажилласан. Энэ хугацаанд бол бид бараг 9 сар энэ эмийн хуулийн төсөл дээр ажиллаж, бараг тухайн хуулийн төсөл үндсээрээ өөрчлөгдөж концепт нь бүүр өөрчлөгдөж өөр болсон учраас Засгийн газар буцаад татаж аваад, дахиж өргөн барина гэсэн байгаа. Тэгэхээр энэ Түр хорооны ажилтай бас энэ эмийн хууль бас заавал уялдах ёстой.

Тэгэхээр Засгийн газар мэдээж барих Эмийн хуулийн төслөө бол барина гэдэгт бол эргэлзэхгүй байна. Энийгээ барих байх гэж бодож байна. Тэгэхээр манайх энэ түр хороо бол ер нь энэ намрын чуулгандаа багтаад бас ажлаа хийгээд дүгнэлтээ гаргачихвал их чухал байгааг бас гишүүддээ уламжилж хэлмээр байна.

Б.Бейсен: Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Манай энэ Түр хороо бол иргэдийн хамгийн их хүсэн хүлээж байгаа асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх ийм Түр хороо байгаа. Сая бас манай гишүүд хэлж байна. Үнэхээр цаг хугацаа алдчихсан. Учрал гишүүнээр ахалсан түр

хороо яг эмийн асуудал дээрээ үнэхээр дорвитой өөрчлөлт хийх байх гэж бид найдаж байсан. Тэгэхдээ бас өөр ажилд томилогдсон нэг талаас. Нөгөө талаасаа энэ эмийн мафи чинь ёстой бүтэхгүй юм байна гээд хэлсэн л дээ. Учрал сайд өөрөө надад бас хэлж байсан.

Тэгээд би энэ асуудлыг бол бас анхнаас нь нэлээд анхаарал хандуулж явж байгаа. Нийгмийн бодлогын байнгын хорооны дарга байхдаа бас энэ аудитын газраар ийм гүйцэтгэлийн аудит хийлгэсэн. Дээрээс нь Азийн хөгжлийн банкны бас судалгаануудыг бид нар авч хамтарч ингэж хийсэн. Эндээс харахад манай энэ эмийн зах зээл дээр жишээлбэл 500 гаруй тэрбум төгрөг эргэлдэж байна. Энэ мөнгө яг хаашаа яаж ордог, энэ нь өнөөдөр бас схем нь тодорхойгүй. Энэ асуудлыг гаргаж ирж гүйцэтгэлийн аудитын тухай асуудлуудыг хөндсөнөөс болоод олон нийтийн сүлжээ хэвлэл зарим хэвлэл мэдээллийн хэрэгслээр бол нэлээд дайруулж шахуулж ч байсан. Гэхдээ бид нар бас тодорхой хэмжээгээр бас Нийгмийн бодлогын байнгын хороо гишүүд үр дүнд бол хүрсэн. Одоо бид нарын авсан энэ гүйцэтгэлийн аудит судалгаанаас харахад л импортын эмийн 16 хувь нь, дотоодод үйлдвэрлэж байгаа эмийн 19,6 хувь нь л гэхэд чанарын шаардлага хангахгүй гарал үүсэл нь тодорхойгүй гэсэн сүүлийн судалгаа байгаа.

Энэнээс гадна олон улсын эмийн үнэ судлах аргачлалаар хийсэн судалгаагаар манай дотоодын зах зээл дээр байгаа эмийн бараг 41 хувь гэж байгаа юм. Тэр нь 10-аас 15 дахин буюу бүүр 540 хувиар зарим нэг эм өндөр үнээр зарагдаж байгааг энэ гүйцэтгэлийн аудит АХБ-ны судалгаагаар харуулсан. Энийг нотлох баримт нь юу байна гэхээр манай ард иргэд эм тарианд зарцуулж байгаа мөнгө нь өрхийн орлогыг хоосруулж ядууралд хүрэх нэг номерын шалтгаан болж байна гэж ярьж байгаа. Сая би бас тойрогтоо иргэдтэй уулзахад бүгдээрээ энэ эмийн үнэ, чанар дээр анхаараад гишүүнээ өгөөч. Та нар маань үнэ буулгасан гэж

яриад байгаа. Гэтэл энэ эмийн сан дээр ирэхэд нөгөө эм маань өндөр үнэтэй. Харин ч бүүр зарим нь үнэ нь өсчихсөн байгаад байна гэж ярьж байгаа. Нөгөө талаасаа эмийн чанар дээр бол бид нар үнэхээр мафижсан уу мафижаагүй тухай яриад ч хэрэггүй үнэхээр тааруу байгаа. Жишээ нь Индонез, Филиппин улс бол эмийнхээ мафид бид үнэхээр баригдчихлаа гэдгээ зарлаад, цагдаа хүчний байгууллагатайгаа нийлээд энэ хүмүүстэйгээ тэмцэж байна л даа. Манайд бол үнэхээр хэцүү байгаа.

Тийм учраас би бас нэр дэвшиж байгаа Чинбүрэн гишүүнээс асуух гээд байна л даа. Энэ Эм, эмнэлгийн тухай хуулийн ажлын хэсгийг та бас ахалсан, ахалж байсан. Тэгээд энэ хуулийг бид нар бас цаг алдалгүй гарах гэж хаана хаанаасаа шахаж үнэхээр хичээсэн. Та өөрөө ч маш их хичээсэн. Гэхдээ та үнэхээр дийлэхгүй юм байна энэ хуулийг гацаагаад энэ явуулахгүй байна гээд та бас чадаагүй. Тэгээд сүүлдээ цаг хугацаа гацсан, буцаасан. Тэгэхээр энэ хууль энэ Эмийн түр хорооны сонсголын үр дүн 2 бол маш их чухал ач холбогдолтой. Тэгээд энэ бол их дайралтад өртдөг асуудал. Яагаад гэвэл би энэ гүйцэтгэлийн аудит хийлгээд энэ эмийг гаргаж ирснийхээ дараа яг өөрөө ч гэр бүлээрээ ч сошиалаар маш их тийм шархдал дайралтад өртсөн.

Гэхдээ 100 доллароор борлуулж байсан эмийг 1 доллар болгох новацын тэр зах зээлийн үнийг нь Монголд нь оруулж ирэх зэргээр тухайн үеийн Эрүүл мэндийн сайд Энхболдыг манай Нийгмийн бодлогын байнгын хороо бас шахаж ажилласны үр дүнд тодорхой бас үр дүн гарсан. Тийм учраас ингэж ч бие дааж яг үнэхээр энэний ард гарч тэр өргөн олон түмнийхээ ядууралд хүргээд байгаа энэ эмийн үнийг буулгаж, бодит зах зээл дээр нь авчрах энэ зориг, хүч байгаа юу гэдгийг би нэгд асуумаар байна.

2-т нь энэ бол нэг хүний тийм шоу болж огт болохгүй. Харин энэ Түр хорооны гишүүд хамтдаа нийлээд яг энэ эмийн үнэ, чанар дээр бид хувьсгал хийх

ёстой. Тэрнээс бид нар тийм мэдээллийн чанартай юм уу, танин мэдэхүйн чанартай, мафижсан уу мафижаагүй юу, үнэ өндөр байна уу, үнэгүй байна уу гэдэг асуудал бол байх ёсгүй. Энэ угаасаа ингэчихсэн гэдэг нь тодорхой болчихсон юм шүү дээ. Гуравхан компани монополчлоод явж байна. Цаана нь зүгээр эд нарын нэрийн доор III компанийн үйл ажиллагаа явуулж байгаа ч байхгүй байна гэж байгаа юм. Эмийн үйлдвэр гэдэг нь эмийн хянан шалгах лаборатори дээр Туваан гишүүн бид 2 Учрал гишүүнтэй очиж үзсэн. Манай Монголын ганц эмийг шалгадаг лаборатори нь тоног төхөөрөмж нь 5-хан тэрбумын асуудлаа ч шийдэж чадахгүй, тоног төхөөрөмж нь үнэхээр хүнд, тэгээд тэнд ажиллаж байгаа хүмүүс нь сэтгэлээрээ ажилладаг. Эмийн чанараа шалгаж тогтооход хэцүү байна гэж ярьж байгаа. Хажууд нь хувийн хэвшлийн Моносын лабораторид бид бас очсон, шал өөр ажиллаж байгаа. Гэхдээ төр хянах ийм лаборатори нь өөр байх ёстой.

Тэгэхээр энэ өөрөө асуудал нь тодорхой байгаа. Харин бид энэ асуудал энэ мафижсан энэ системийг энэ Эрүүл мэндийн даатгалын сангийн хамаг мөнгө сая хаашаа орсныг бас саяхан гаргаж ирсэн шүү дээ. Монголын ямар, ямар компаниуд руу орчихсон, үр дүн ямар байсан нь. Тэгэхээр энийг та зоригтой хийж чадах уу гэж.../минут дуусав/

Б.Бейсен: Чинбүрэн гишүүн.

Ж.Чинбүрэн: Нэгд Эмийн хуулийн төсөл дээр би чадахгүй нь гэж үг хэлсэнээ ерөөсөө мэдэхгүй юм байна. Зүгээр тухайн 2 Засгийн газар дамжин хууль нь бол өргөн баригдчихсан байсан. 2 Засгийн газар дамжчихсан байсан. Бид 20 оны бас эрүүл мэндийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд Эмийн агентлаг гэж шинэ байгууллага байгуулагдсан. Тэрэнтэй холбоотой хуулийн төсөлд эмийн агентлагийн асуудал бас ороогүй байсан. Маш түүхий байсан учраас бид энийг бол бүтэн 6 сар бүүр тасралтгүй ажиллаад, тэгээд энийг Засгийн газар буцааж бид

нарын янзалж өгснөөр нь ингээд өргөн барих тухай яриад өгсөн. Түүнээс бол бүүр дийлэхгүй нь, болохгүй нь гэж бас хэлсэн гэдгийг би ерөөсөө тэгж хэлээгүй.

2-т хувь хүний хувьд бол надад ямар нэгэн ашиг сонирхлын зөрчил байдаггүй. Би хувийн нэг ч эмийн сан, эмнэлэг оруулж ирдэг компани гэдэг юм уу тийм юмнууд байхгүй. Эмч хүний хувьд бол ер нь эмчийн гол ажлын үр дүнгийн гол зэвсэг нь өөрөө эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний чанартай шууд холбоотой. Тэгээд энэ утгаараа бол Монгол Улсад тэр дотроо миний өөрийн баримталдаг үзэл бодол бол бид дэлхийн анагаах ухааны хамгийн сайн бүтээгдэхүүнүүдийг технологиудыг, аргачлалуудыг эх орондоо, ард түмэндээ санхүүгийн дарамтгүй хүртээх ийм том зорилго тавьж байгаагийн үндсэн гол хэрэгсэл нь энэ эм. Тийм учраас бас энэ эмийн үнэ хэр бодитой байгаа гэдэг бол манай энэ зах зээл дээр байгаа муу чанаргүй эмийг хэт үнэтэй зараад байгаа гэдэг бол нэлээн олон баримт нотолгоогоор байгаад байгаа учраас энэ тогтолцоог засаж байж, хэн нэгэн бид энийг хуулиар л янзлахгүй бол зүгээр ганц нэг компанитай, ганц нэг эмийн судалгаатай ноцолдоод бол энэ дийлэхгүй.

Тийм учраас бид тогтолцоог зөв болгох тэр талаар л би энэ монопол, олигопол тогтолцоог, тэр шударга биш өрсөлдөөнийг дэмжиж байгаа тогтолцоог үгүй болгох тал дээр бол анхаарал тавьж ажиллана гэж бодож байгаа. Тэр ч утгаараа би энэ анх энэ Эмийн түр хороо байгуулах төслийг санаачлаад, энэ 18 гишүүний гарын үсэг зуруулахдаа ерөөсөө энийг л ярьж явсан. Тэгэхээр бидэнд бол энэ үйл явцыг хийхэд Түр хорооны гишүүд та бид бүгдээрээ л хамтарч хийхээс энэ нэг ганц нэг хүний хийх эсхүл энэ энүүгээр ямар нэг тийм улс төрийн ашиг хонжоо олох гэж явна гэх юм бол энэ угаасаа утгагүй. Тэгэх юм бол энийг хийсний ч хэрэг байхгүй. Энэ бол нийтдээ 3,4 сая иргэддээ эрүүл мэндийн энэ тусламж үйлчилгээг сайн болгох гол хэрэгслүүр болж байгаа ийм л хэрэглэгдэхүүнийхээ л чанарыг

сайжруулья л гэсэн ийм чин сэтгэлээр л энэ бичгийг өргөн барьсан.

Б.Бейсен: Оюунчимэг гишүүн 1 минут.

М.Оюунчимэг: Би Чинбүрэн гишүүндээ итгэж байна. Мэдээж бас мэргэжлийн хүн ахлаад яваад энийг хийнэ гэдэгт бол итгэлтэй байна. Тийм учраас л энэ чинь нэг хүний нөгөө асуудал биш. Яагаад гэвэл Учрал гишүүн өөрөө ч надад хэлсэн. Та бас бүлгийн манай нөгөө групп дээр хүртэл бөөн асуудал болоход энийг явуулах сонирхолгүй хүмүүс байдаг юм байна гээд та өөрөө бас хэлж байсан учраас би таныг нөгөө зоригтой энэ ажлыг бол бас зориг зүрх үнэхээр хэрэгтэй юм байна лээ шүү. Тийм учраас багийн ажил, багаараа хийнэ. Энэ Түр хорооны гишүүд бүгдээрээ цаг хугацаа алдахгүй нээлттэй сонсголыг хийнэ. Ингэхдээ бэлтгэлээ маш сайн хангах ёстой. Бүх талын материалууд байгаа. Аудитын газар энэ дээр бол ёстой маш их мэргэшичхсэн байгаа. Иргэд ч маш их хүсэн хүлээж байгаа. Тийм учраас л энийг та ингэж яг багтайгаа мэдээллүүдээ бүгдээрээ яг хуваалцаад, ажлаа бүрэн тэгш хувааж аваад хариуцлагатай байгаад, нэгдмэл зүрхээр хийвэл бид бас иргэдийн хүсэн хүлээгээд байгаа ийм эмийн үнэ, чанар дээр өөрчлөлт хийх бололцоо энэ хяналтын сонсголоор гарч болно гэж найдаж байгаа шүү гэдгийг хэлчихье. Баярлалаа.

Б.Бейсен: Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны хуралдаан Сандаг-Очир гишүүн ирснээр 100 хувийн ирсний хуралдаж байна. Энэ би бас нэг саналаа хэлчихье. Энэ эмийн үнийн өсөлтийг шалгах энэ түр хороо яах аргагүй цаг үеэ олсон байгуулагдах түр хороо гэж бодож байна. Хөдөө орон нутагт ч ажиллаад ирлээ. Эмийн бас нэлээн өссөн байна. Хавар Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын гаргаж өгсөн мэдээгээр бид нарт өгсөн гаалиас яг хэрэглэгчид хүрэх хүртэл эмийн үнэ бол 3 удаа 10 хувийн НӨАТ төлж байгаа. Хил

гаальд 10 хувь, тэгээд эм ханган нийлүүлэхэд байгаа 10 хувийн НӨАТ, тэгээд эмийн сан бас 10 хувийн НӨАТ төлж байгаа. Энийг Засгийн газрын түвшинд ярьж та шийдүүлж чадах уу 1 дүгээрт?

2 дугаарт өргөн хэрэглээний жишээлбэл зүрх судас, даралтын эм, амьсгалын замын эм, бөөр, шээс дамжуулах замын эмүүд маш үнэтэй болсон байна. 10Мг-ын деротон авахад 22-23 мянга, 10 ширхэг шүү дээ. Ийм үнэ өссөн байна. Одоо хөнгөлөлттэй эмийг ард иргэд авч чадахгүй байна. Мөн энэтэй холбоотой тендерийн эмүүдийн үнэ өссөн, улсын төсөвт бас нөлөөлж байна. Тийм учраас энийг нарийн шалгахгүй бол бас болохгүй байна. Тэр хил гаалиас ирсэн юмыг чинь бөөний төвүүд бас 20-30 хувь нэмдэг, эмийн сан мөн ханган нийлүүлэх байгууллагууд нэмдэг энэ асуудлыг цэгцэлж чадах уу 1 дүгээрт.

2 дугаарт энийг судлахгүй бол бас болохгүй. Үнэхээр үнэтэй орж ирж байна уу үгүй юу. Тэр танилцуулга дээр бас Эм, эмнэлгийн хэрэгслийн газрын танилцуулга дээр чинь зарим эм 200 хувь нэмэгдсэн гэсэн. Сая Оюунчимэг гишүүн ярьж байна. Нийгмийн бодлогын дарга байхдаа бас энд аудит хийлгэж байсан бас тухайн үед нь бид нар ажиллаад тэр эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн тэр төв лаборатори дээр очиж байсан. Үнэхээр тоног төхөөрөмжийн дутагдалтай ийм асуудлууд байж байгаа. Энийг бас цаашаагаа тавих шаардлагатай байх гэж бодож байна. Санал хураалт явуулъя. Чинбүрэн гишүүн хариулах юм байна.

Ж.Чинбүрэн: Хурал даргалагчид баярлалаа. Ер нь энэ бид нарын Түр хороо бол нөхцөл байдлыг үнэлээд, ийм байна шүү ийм болохгүй байна шүү, энийгээ засаарай гэсэн зөвлөмж өгөхөөс бид шууд Засгийн газрын ажлыг шууд хийж чадахгүй л дээ. Тэгэхдээ та яг зөв хэлж байна. Өнөөдөр энэ үнэ нэмэгдээд байгаа давхардсан НӨАТ-ын асуудлууд ч хүртэл байж байна. Тийм учраас манай ажлын

хэсэгт бас энэ орон нутгаас сонгогдсон, Нийслэлээс сонгогдсон, дээрээс нь Нийгмийн бодлогын байнгын хороон даргаар ажиллаж байсан, эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа, ажиллаж байсан 3 ч хүн ингээд байж байна.

Дээрээс нь Нийгмийн бодлогын байнгын хорооны энэ анхан шатны тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахаар тогтоолын төслийг хүртэл удирдаж байсан ийм гишүүд байгаа нь өөрснөө бид нарыг энэ ажлыг хамтдаа маш сайн хийх энэ нөхцөл боломж бүрдэж байгаа гэдэгт би бас их дотроо баярлаад байгаа юм. Тийм учраас түрүүн Оюунчимэг гишүүний хэлдгээр энэ бол хамтын ажил. Энэ нэг хүн хийх гээд байгаа юм биш. Харин бид бид хамтаараа ажлын төлөвлөгөө гаргах, ямар, ямар чиглэлд судалгаанууд хийх вэ гэдэг дээр та бүгдийн саналуудыг хэрвээ энэ ажлыг ахалж ажиллахаар болох юм бол бүгдийг нь нэгтгэж, аль болохоор л бүгдээрээ хамтаараа яг л тэр Хөгжлийн банкттай холбоотой сонсгол сонсдог шиг ер нь бол их шуурхай, их зөв экспертүүдийг, тэгээд хянан шалгагч нараа их зөв томилж ингэж ажиллах нь чухал юм.

Тэгээд бидэнд цаг хугацаа их бага байгаа учраас их шуурхай. Харин би та бүгдээс, гишүүдэд бас тусгайлан энэ дээр энэ Түр хороонд орж ажиллаж байгаа гишүүддээ бас тусгайлан цаг гаргаж, аль болохоор энэ ажлаа 1 дүгээрт тавьж, түрүүн бас гишүүд та бүгдийн хэлж байгаагаар үнэхээр манай Монгол Улсын тулгамдсан том аюулгүйн асуудлын нэг хэсэг учраас бүгдээрээ энэ дээр идэвхтэй ажиллахыг бас уриалж байгаа юм. Баярлалаа.

Б.Бейсен: Түр хорооны даргад нэр дэвшиж дууслаа. Санал хураалт явуулъя. Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үрэг бүхийг хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшигч Чинбүрэнг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Үгүй ээ болоогүй байж байгаарай, болоогүй болоогүй. Туваан гишүүний тоног

төхөөрөмж ажиллаагүй юм байна, 100 хувийн санал хураалтаар ингээд л санал хураалтын дүнг танилцуулъя. Хянан шалгах түр хорооны даргад нэр дэвшигч Чинбүрэнг нийт гишүүд дэмжсэн учраас, татгалзсан гишүүн байхгүй, 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Түр хорооны тогтоолын төслийг танилцуулъя. Дугаар номер 1. Түр хорооны даргыг нь сонгох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.5 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг, Хянан шалгах түр хороо байгуулах тухай Монгол Улсын Их Хурлын 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолыг үндэслэн Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий хянан шалгах түр хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жигжидсүрэнгийн Чинбүрэнг сонгосугай.

2.Энэ тогтоолыг 2023 оны 10 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Хурлын даргалагч Бейсен. Даргаар сонгогдсон Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүнийг суудалдаа урья.

Ж.Чинбүрэн: Хуралдаан даргалсан Бейсен гишүүнд баярлалаа. Мөн итгэл үзүүлсэн Түр хорооны ажлын гишүүддээ бас баярлалаа. Мэдээж амаргүй энэ ажил. Гэхдээ бид амархан байдаг байсан бол бүгдээрээ л хийчих байх. Тэгэхээр энэ тогтолцооны том шинэчлэл хийх гэж байгаа учраас эрхэм гишүүд бүгдээрээ бас хамтраад энэ тогтолцоог илүү сайн, зөв тунгалаг болгож бас түүхэн том шинэчлэл хийнэ гэдэгт бас итгэлтэй байгаа.

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4-д Улсын Их Хурлын гишүүний өмнөх эсхүл одоогийн үйл ажиллагаанд тусгай шалгах тухайн асуудалтай холбоотой бол уг гишүүнийг Түр хорооны бүрэлдэхүүнд оруулахыг хориглоно гэж заажээ. Тиймээс гишүүд энэ талаар саналтай бол энэ долоо хоногтоо багтаж Түр хорооны даргад мэдээллээ ирүүлэхийг хүсье. Ашиг сонирхлын зөрчлөө илэрхийлэх юм байна.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул энэ өдрийн хуралдаан өндөрлөснийг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн гишүүддээ баярлалаа. Долоо хоногийн хугацаанд юугаа яах юм байна.

11.33 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА